

## ШЭНЬЖЭНЬ ХОТ

Н.ТӨМӨР\*

БНХАУ-ын Шэньжэнь хотыг байгуулах шийдвэрийг 1979 онд анх гаргаснаас хойш ердөө 27 жил өнгөрчээ. Гуандун мужийн нутаг дэвсгэрт орших Шэньжэнь хотод ХКН-ын Төв Хороо болон БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс 1980 оны 5-р сард шийдвэр гарган “Эдийн засгийн онцгой бүс” байгуулжээ. 1948.69 хав.дөр. км талбай бүхий энэ хотод буй “Эдийн засгийн онцгой бүс”-ийн талбай нь 391,71 хав.дөр.км талбайг эзэлнэ. 2000 онд болсон Бүх Хятадын 5 дахь удаагийн хүн амын тооллогоор Шэньжэнь хотын нийт хүн амын тоо 7.01 сая, “Эдийн засгийн онцгой бүс” 2.56 сая хүн амтай байв. Шэньжэнь хот нь Лоху, Футянь, Наньшань, Яньтянь, Бао-ань, Лунган зэрэг нийт 6 дүүргээс бүрдэх бөгөөд үүнд эхний дөрөв нь “Эдийн засгийн онцгой бүс”-д багтах юм. Лоху дүүрэг нь “Эдийн засгийн онцгой бүс”-ийн зүүн хэсэгт орших бөгөөд Шэньжэнь хотын санхүү эдийн засаг болон худалдааны төв, урдуураа Хонконгтой хил залгадаг. “Эдийн засгийн бүс”-ийн төв хэсэгт оршдог, Футянь дүүрэгт Шэньжэнь хотын захиргаа байрладаг бөгөөд тус хотын соёл, мэдээлэл, олон улсын үзэсгэлэн болон худалдааны төв юм. Мөн Хонгконгтой хиллэдэг. Наньшань дүүрэг нь “Эдийн засгийн онцгой бүс”-ийн баруун хэсэгт оршиж аж үйлдвэрүүд болон их дээд сургуулиуд энд байрладаг. Бао-ань дүүрэгт нарийн техникийн механизм үйлдвэрлэхээс гадна боловсруулах үйлдвэр мөн нилээд хөгжсөн. Шэньжэнь хот Хонгконг, Дунгуань зэрэг эдийн засгийн хөгжлөөр нэлээд хөгжсөн хотуудтай хил залгаа байдаг нь түүний эдийн засгийн хөгжилд шууд нөлөөлөх нь дамжиггүй. Шэньжэнь нь далайн боомт хот, нийт 6 боомттой. Энэхүү 15 км урт бүхий далайн эрэг дээр байгуулсан 6 боомт 20 тэрбум юаний үндсэн хөрөнгөтэй. Нийт

усан тээврийн 33 компаний 190 усан онгоц энд усан тээврийн ажил эрхэлдэг. Сар бүр дунджаар 200 гаруй төрөл бүрийн усан онгоц дээрх боомтоор дамжуулан Америк, Европ, Австрали, Зүүн өмнөд Ази, Япон руу далайн тээвэр хийдэг байна. 2001 оны байдлаар дээр дурдсан боомтоор нийт 66425.4 мян тн буюу 5070 мян стандарт чингэлгийн ачаа тээвэрлүүлсэн нь Хятад улсын хэмжээнд 2-т, дэлхийн хэмжээнд 8-т орж байлаа.

Шэньжэнь нь далайн, агаарын, хуурай замын 3 төрлийн боомттой БНХАУ-ын цорын ганц хот юм. Энэхүү давуу тал тус хотын эдийн засгийн хурдацтай хөгжилд нөлөөлжээ. Дээр дурдсан далайн 6 боомтоос гадна Лоху, Хуанган, Вэньжинду, Шатоу зэрэг хуурай замын 4 боомттой, Бао-ань нэртэй олон улсын онгоцны буудалтай. 2001 оны байдлаар дээрх боомтуудаар нийт 117 сая хүн/удаа, 91.45 сая машин/удаа дамжин өнгөрсөн нь Хятад улсын хэмжээнд 1-т оржээ. Шэньжэний Иргэний агаарын тээвэр нэлээд сайн хөгжсөн. Тухайлбал, 2006 оны байдлаар Шэньжэнь нь Бээжин, Шанхай, Тяньжин, Чунчин, Харбин, Шэньян, Чэнду, Хөх хот зэрэг Хятадын томоохон хотууд руу өдөр бүр шууд нислэгтэй байхаас гадна Москва, Токио, Осака, Сөүл, Стамбул, Лос Анжелос, Ванкувер зэрэг дэлхийн хотууд руу мөн тогтмол нислэгээр үйлчилж байна. Шэньжэнь хотын төмөр замын харилцаа мөн нэлээд хөгжсөн бөгөөд өдөр бүр 74 галт тэрэг Шэньжэний галт тэрэгний буудлаас Бээжин, Хэфэй, Зюзян, Ухань, Чанша, Вичинь, Шаогуань, Мэйжоу, Шаньтоу, Хонконг зэрэг Хятадын томоохон хот руу явж мөн тооны галт тэрэг тэдгээр хотуудаас Шэньжэний галт тэрэгний буудалд ирдэг. Төмөр замаас гадна өндөр хурдны авто замаар Шэньжэнь-Гуанжоу, Шэньжэнь-Хонконг хотуудыг холбосон бөгөөд өдөр бүр

\* Н.Төмөр.ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

150 автобус Шэньжэнь-Гуанжоугийн хооронд, 300 автобус Шэньжэнь-Хонконгийн хооронд тогтмол үйлчилдэг байна.

Шэньжэнь хот нь БНХАУ-ын эдийн засгийн хөгжлөөр хамгийн хурдацтай хөгжиж буй хотуудын нэг нь юм. 1979 оны байдлаар нэг хүнд ноогдох ДНБ (GDP) 606 юань байсан бол 2001 онд 43355 юань болж тухайн үеийн ханшаар барагцаалбал, 5237 ам.долларт хүрсэн нь Хятад улсын том, дунд хэмжээний хотуудыг тэргүүлэв.

Шэньжэний аж үйлдвэрүүд тус хотын 174,4 хав. дөр.км талбай бүхий Лунган хэмээх дүүрэгт голлон байрладаг бөгөөд үйлдвэрүүдийн гол чиглэл нь цахим тооцоолон бодох машины үйлдвэрлэл юм. Тухайлбал, хятадын тооцоолон бодох машины процессорын 50%, соронзон толгойн 90%, принтерийн 42,9%-ийг Шэньжэнь-д үйлдвэрлэж байна. Түүний зэрэгцээ микросхем, телевизор, хагас дамжуулагч хүлээн авагч болон харилцаа холбооны хэрэгслийн үйлдвэр мөн нэлээд хөгжсөн. Бүх Хятадын өнгөт телевизрийн 15,75%-ийг үйлдвэрлэн, үйлдвэрлэлийн хэмжээгээр улс орондоо 2-р байранд ордог. 1985 онд байгуулагдсан “Жунсин тунсюнь” хэмээх харилцаа холбооны хэрэгслийн үйлдвэр худалдааны компани эдүгээ дэлхийн 100 гаруй улс орны 500 гаруй холбогдол бүхий пүүс компанитэй ажил хэргийн холбоо тогтоон, 300 сая хэрэглэгчдэд үйлчилдэг бөгөөд манай оронд 2005 оноос төлөөлөгчийн газраа нээн үйл ажиллагаагаа явуулж эхлэв. 2004 оны байдлаар энэхүү компани нийт 34 тэрбум юаний барааны захиалга ирүүлжээ. “Жунсин тунсюнь” компани үйлдвэрлэл үйлчилгээ явуулахын зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулан, тус компанийн ашиг орлогын 10 орчим хувийг үүнд зарцуулан АНУ, Энэтхэг, Швед болон дотооддоо 13 эрдэм шинжилгээний төв байгуулан ажиллуулж байна.

Шэньжэнь хот Зүүн өмнөд Азийн бүс нутагт хувилагч машины үйлдвэрлэлээр тэргүүлдэг бөгөөд энэхүү бүтээгдэхүүнээр хятадын зах зээлийн 48.28%-ийг хангадаг билээ. Хөнгөн аж үйлдвэрээс эм, эмчилгээний багаж хэрэгсэл, нарийн техник механизм, хүнс зэрэг үйлдвэрүүд байдгаас “дэлхийн бугуйн цагны 45%”-ийг Шэньжэнь хотод

үйлдвэрлэдэг юм гэж “Shenzhen Basic Facts-2002”-д бичжээ.

Шэньжэнь, Хонконгийн эдийн засгийн хамтын ажиллагаа өдрөөс өдөрт улам эрчимжин улс ардын аж ахуйн олон салбарт нягт холбоотой ажиллаж байна. Тухайлбал, Хонконг Шэньжэнь-д буй “Да-я-вань” хэмээх цөмийн цахилгаан станцаас цахилгаан эрчим хүч, “Шэньжэнь усан сан”-гаас жилд 1.1 тэрбум шоо м цэвэр ус, мөн мах, өндөг, идэшний ногоо, сүү зэрэг бүтээгдэхүүн авдаг билээ. Шэньжэнь хотын гадаад хөрөнгө оруулалтын 70 орчим хувийг Хонконг эзлэн, 2001 оны байдлаар 10 мянга гаруй Хонконгийн үйлдвэр аж ахуйн газар Шэньжэнь-д ажилладаг. Хонконгоос гадна дэлхийн 70 гаруй орны хөрөнгө оруулагчид 2001 оны байдлаар Шэньжэний 27030 объектод нийт 26.617 тэрбум ам.долларын хөрөнгө оруулжээ.

Шэньжэний Их сургууль 1983 онд байгуулагдаж эдүгээ тус их сургуулийн 14 дээд сургуульд нийгмийн ухаан, тоо физик, үйлдвэр, эдийн засаг, удирдахуйн ухаан, хууль зүй, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг 8 чиглэлийн 54 мэргэжлээр 16741 оюутан суралцахаас гадна, 1245 магистрант /1996 оноос эхлэн магистрын зэрэг олгох эрхтэй болсон/, 14 докторант /2006 оны 1-р сараас докторын эрх олгох эрхтэй болсон/, 40 гаруй орны 920 гадаадын оюутан тус тус суралцдаг. Тус их сургуульд Бээжингийн их сургууль, Цинхуагийн их сургууль зэрэг хятадын нэртэй их дээд сургуулиудаас томилогдсон туршлагатай багш нар ажиллаж байгаа бөгөөд докторын зэрэгтэй 374 багш, магистрын зэрэгтэй 469 багш байна. Хятадын ШУА-ийн академич нар уригдан тусгай мэргэжлийн хичээл заадаг. Шэньжэний их сургууль сургалт явуулахаас гадна эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулдаг бөгөөд үүнд зориулсан тоног төхөөрөмжийн үндсэн хөрөнгийн хэмжээ нь 438.4 сая юаньд хүрчээ. Шэньжэний их сургууль АНУ, Англи, БНСУ-ын их дээд сургуулиудтай харилцаа тогтоон, жил бүр оюутан, багш нарыг солилцдог юм. Энэ их сургуульд нэлээд баялаг номын сантай, нийт 2120 мян. хэвлэмэл ном, 1040 мян. цахим ном, 40 мян. төрлийн цахим сэтгүүлтэй.

**Ашигласан материал:**

1. "Blue book of Shenzhen" (2003), "Social Sciences Documentation Publishing House", Beijing, 2003.
2. "Blue book of Shenzhen" (2004), "Social Sciences Documentation Publishing House", Beijing, 2004
3. Timetable of "Air China", 2006.
4. "Цыхай" /"Үгсийн далай"/, Шанхай, 2000.
5. "Shenzhen Basic Facts-2002", Шэньчжэнь, 2002.
6. <http://www.news.xinhuanet.com>, "Шэньчжэнь хот байгуулагдсаны 25 жилийн ой".
7. <http://www.zte.com.cn>, "Чжунсин тунсюнь".
8. <http://www.szu.edu.cn>, "Шэньчжэний их сургууль", 2006 оны 3-р сард засвар өөрчлөлт хийсэн текст